



ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ ГАЗАР



ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГАА



**УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ  
ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН  
ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН,  
ЭРҮҮЛ АХУЙН БҮС ТОГТООХ**

## **ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ**

Усны эх ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх, усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, цаашид усан орчинд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн боломж, нөхцөл бүрдэх

# ҮНДЭСЛЭЛ

## Усны тухай хууль

**22.1.** Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно

### 11.1.4. /Аймаг, Нийслэлийн ИТХ-ын бүрэн эрх/


Энэ хуулийн **22.1-22.4-т** заасны дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг хот, суурины ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтоох

### 12.1.4, 13.1.6 /Аймаг, Нийслэлийн болон сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх/

Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж бүсийн дэглэмийг мөрдүүлэх/

*Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хэвсралт* **УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН, ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН ДЭГЛЭМИЙГ МӨРДӨХ ЖУРАМ**

# БОУАӨЯ БОЛОН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДҮГНЭЛТ




Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн зураглалыг БОУАӨЯ, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн Ерөнхий газарт дүгнэлт гаргуулах хүсэлтийн хамт явуулж, БОУАӨЯ-ны 2024.10.02-ны өдрийн 02/4604 тоот, ГЗБГЗЗЕГ-ын 2025.06.17-ны өдрийн 1/2121 тоот дүгнэлт тус тус гаргуулсан.

## Онцгой хамгаалалтын бүс

Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд **ОНЦГОЙ ХАМГААЛАЛТЫН БҮС** тогтооно.

- Монгол улсын усны тухай хууль /22.2/
- Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам /2.3/



Онцгой хамгаалалтын бүсэд:

## Зөвшөөрнө

- Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж барих, ашиглах
- Гадаргын усыг ус хангамжийн эх үүсвэрт ашиглах тохиолдолд гадаргын усыг цэвэршүүлэх байгууламж барих
- Эргийн тохижилт хийх
- Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, гольфоос бусад спорт тоглоомын талбай байгуулах, мод бут сөөг тарих
- Хяналт шинжилгээний цооног гаргах, хяналт шинжилгээ явуулахыг зөвшөөрнө

## Хориглоно

- Зуслан суурьшлын бүс байгуулах
- Барилга байгууламж барих
- Газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх
- Ашигт малтмал хайх олборлох
- Зэгс, шагшуурга, мод огтлох
- Элс хайрга, чулуу олборлох
- Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх
- Мал угаах болон ХАА-ын бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

## Онцгой хамгаалалтын бүс

30 м хүртэлх зайд  
Үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас


50м-с доошгүй зайд  
Гол мөрөн, горхи, булаг шандын эргээс  
Түүнээс өргөн намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж

Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх үерийн хамгаалалтын далангаас

100м-с доошгүй зайд  
Нуур урсацын тохируулгатай усан сангийн эргээс

Гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнцүү хэмжээний зайд

Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс




Голын эрэг

Онцгой хамгаалалтын бүс

## Энгийн хамгаалалтын бүс

Усны сан бүхий газрын эргээс  
200 метрээс доошгүй зайд  
**ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН  
БҮС** тогтооно.



- Монгол улсын усны тухай хууль /22.3/
- Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам /2.6/


Энгийн  
хамгаалалтын  
бүс

200 м-с доошгүй зайд

Усны сан бүхий газрын  
эргээс

500 м хүртэлх зайд

Нийслэл болон аймгийн  
төвийн хот суурины нутаг  
дэвсгэр дэх усны сан бүхий  
газрын эргээс



Голын эрэг

Онцгой хамгаалалтын бүс

Энгийн хамгаалалтын бүс

Энгийн  
хамгаалалтын бүс:

## АНХААРАХ ЗААЛТ

- Хур бороо болон шар усаар түр зуурын хугацаанд тэжээгдэн урсан өнгөрөх, тогтоол ус үүсэхгүй, тогтмол тэжээлгүй голдирол бүхий хуурай сайранд онцгой болон энгийн хамгаалтын бүс тогтоохгүй
- Энгийн хамгаалалтын бүс нь онцгой хамгаалалтын бүсээс дотогш байж болохгүй

## ХОРИГЛОНО

- Мод бут огтлох
- Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжгүй буюу ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах
- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, цацраг идэвхт бодис, бүх төрлийн бордоо, пестицид хадгалах, ашиглах
- Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах
- Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах
- Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах
- Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах


Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоосон байдал

| №    | Сумын нэр  | Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс /га/ |                                         | Төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс /га/ |                        | Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс /га/ |                                                          |
|------|------------|---------------------------------------------|-----------------------------------------|---------------------------------------------------------------|------------------------|-----------------------------------------------------------|----------------------------------------------------------|
|      |            | Онцгой хамгаалалтын бүсийн талбай /га/      | Энгийн хамгаалалтын бүсийн талбайн /га/ | Хориглолтын бүс /га/                                          | Хязгаарлалтын бүс /га/ | Хориглолтын бүс /га/                                      | Ус дамжуулах түгээх шугам хоолойн Хязгаарлалтын бүс /га/ |
| 1    | Баян-Өндөр | 600.30                                      | 2027.12                                 | 5.48                                                          | 87.91                  | 3.14                                                      | 194.06                                                   |
| 2    | Жаргалант  | 1022.32                                     | 2992.43                                 | 18.02                                                         | 278.72                 | 9.41                                                      | 0.37                                                     |
| Нийт |            | 1622.62                                     | 5019.55                                 | 23.50                                                         | 366.63                 | 12.55                                                     | 194.43                                                   |


Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоосон байдал

| Талбайн хэмжээ /га/          | Гол     | Булаг   | Нийт    |
|------------------------------|---------|---------|---------|
| Онцгой хамгаалалтын бүс /га/ | 1313.15 | 309.20  | 1622.35 |
| Энгийн хамгаалалтын бүс /га/ | 3686.62 | 1332.93 | 5019.55 |

ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН  
БҮСИЙН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ /ХУВЬ/



ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН  
ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ТАЛБАЙН  
ХЭМЖЭЭ /ГА/



Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зураглах явцад лицензийн давхардал:



# Үр дүн

35 булаг шанд, 9  
голын татмыг  
зурагласан

Сумдын удирдлагууд,  
болон иргэдэд  
танилцуулж санал  
авсан

79 УСТ ЦЭГ  
ХАМРАГДСАН


| НИЙТ ЗУРАГЛАСАН                     | ДҮН |
|-------------------------------------|-----|
| ГОЛ ГОРХИ                           | 9   |
| БУЛАГ ШАНД                          | 35  |
| УС ХАНГАМЖИЙН ЭХ<br>ҮҮСВЭР / ХУДАГ/ | 35  |

# ХЭЭРИЙН АЖИЛ






# Голын хамгаалалтын бүс



# Булгийн хамгаалалтын бүс





## УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮСЭД ДАВХЦАЛТАЙ ГАЗАР ОЛГОЛТ

- ✓ Хамгаалалтын бүсийн зураглалыг газрын нэгдмэл сангийн мэдээлэлтэй давхцуулж хамгаалалтын бүсэд орсон талбайнуудыг тодорхойлсон.
- ✓ Газар эзэмшигч, өмчлөгчийн мэдээллийг Орхон аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас авсан. Уг мэдээллийн дагуу давхардсан тоогоор:

### Баян-Өндөр суманд

- Онцгой хамгаалалтад **471**
- Энгийн хамгаалалтад **1185**

Ус хангамжийн төвлөрсөн бүс эх үүсвэрийн

- Хориглолтын бүсэд **170**
- Хязгаарлалтын бүсэд **2042**

Төвлөрсөн эх үүсвэрийн эрүүл ахуйн

- Хориглолтын бүсэд **1** иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэгж талбар

### Жаргалант суманд





- Онцгой хамгаалалтад **162**
- Энгийн хамгаалалтад **412**

Ус хангамжийн төвлөрсөн бүс эх үүсвэрийн

- Хориглолтын бүсэд **10**
- Хязгаарлалтын бүсэд **154**

Төвлөрсөн эх үүсвэрийн эрүүл ахуйн

- Хориглолтын бүсэд **11** иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэгж талбар



Нийт **4618** иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар  
**ХАМГААЛАЛТЫН БҮСЭД ОРСОН.**

# Цаашид тавих санал

- ✓ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор хамгаалалтын бүсийг тогтоох.
- ✓ Орон нутгийн шийдвэрийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-д заасны дагуу онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх.
- ✓ Цаашид усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд газар олголт хийхгүй байх.
- ✓ Хамгаалалтын бүсэд байгаа айл өрх албан байгууллагуудын нүхэн жорлон, угаадасны нүхийг MNS 5924:2015 стандартын дагуу шийдэх нь зүйтэй байна.